



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Хариуцлага тооцох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 19 дүгээр зүйл, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 5 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзон нь ажлын хариуцлага алдсан тул түүний албан тушаалын цалингийн хэмжээг гурван сарын хугацаатай 20 хувиар бууруулсугай.

2. Захирал Б.Гүрсоронзонгийн албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулан тооцож олгохыг Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга (Р.Баасандорж)-д үүрэг болгосугай.

3. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Тээвэр хариуцсан дэд захирал Ц.Эрдэнэчулуун, Өмнөговь аймгийн Автотээврийн төвийн Цогтцэций салбарын дарга Ц.Бямбацогт нарт холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцох арга хэмжээг авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2022 оны 2 дугаар сарын 15 дотор хариуг ирүүлэхийг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Б.Гүрсоронзон)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ